МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБОО | Banking & Finance Academy

# БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2024 он

АЛААГҮЙ БААВГАЙН АРЬСЫГ ХУВААХ НЬ

# Алаагүй баавгайн арьсыг хуваах нь...

Банкны салбарын үзүүлэлт тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 хувиар нэмэгджээ. Чанаргүй зээлийн хэмжээ буурав. 2024 оны эхнээс эхэлсэн төгрөгийн хадгаламжийн өгөөж нэмэгдэх үйл явц үргэлжилсэн хэвээр байна. Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн банкны зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Инфляцын түвшин буулгахад чиглэсэн бодлогын арга хэмжээний нөлөөгөөр инфляц харьцангуй тогтвортой байсан ч оны сүүлийн хагасаас эрэлтээс үүдэлтэй инфляц нэмэгдэж эхэллээ.

Төлбөрийн тэнцэл, тэр дундаа санхүүгийн данс ашигтай гарсан нь валютын нөөцийг нэмэгдүүлж, төгрөгийн худалдан авах чадвар тогтвортой байхад чухал нөлөө үзүүллээ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнтэй холбоотой төсвийн орлого нэмэгдсэн хэдий ч хоёр удаагийн орон нутгийн сонгуулийн нөлөө болон төсөвт тодотгол хийсэнтэй холбоотой төсвийн тэнцэл алдагдалтай гарлаа. Ийнхүү улсын төсөв, урсгал дансны хос алдагдалд хүрч цаашид эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад ихээхэн сорилт дагуулах төлөв байдал үүслээ.

Уул уурхайн салбар болон түүнийг дагасан тээвэр, логистикийн салбарын өсөлт тогтвортой, үйлчилгээ болон худалдааны салбарын өсөлт үргэлжилсэн нь эдийн засаг 4.9 хувиар өсөхөд чухал нөлөө үзүүлсэн. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж оны эхнээс хөдөө аж ахуйн салбар уналттай байсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлжээ.

Уул уурхайн гаралтай эрдэс бүтээгдэхүүний үнийн болон тоон хэмжээний өсөлтөд найдан эдийн засгийн өсөлтийг өндөр байхаар төлөвлөж, төсвийн орлого болон зардлын хэмжээг өндөр түвшинд баталж, төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэн томоохон төслүүдийг эхлүүлэхээр төлөвлөж байгаа нь алаагүй баавгайн арьсыг хуваахтай ижил зүйл болж байна.



# Иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Банкууд иргэдэд хэрэглээний зээл буюу цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл түлхүү олгожээ. Иргэдийн цалин, тэтгэвэр нэмэгдсэн нь зээлийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлж байна.

Онцлох өөрчлөлт, энгийн тайлбар

Онолын тодорхойлолт

Иргэдийн зээл олголт, жил бүрийн эцэст




## Банкны шинээр олгосон зээл

*Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.*

Шинээр иргэдэд олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв.

30%

2024 оны жилийн эцсийн гүйцэтгэл

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

# 2024 ОНД БАНКНЫ САЛБАРТ ГАРСАН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын бизнесийн зээл олголт нэмэгдэж эдийн засгийн салбаруудын өсөлтийг дэмжиж байна.



Банкуудын чанаргүй зээл сүүлийн 15 жилийн доод хэмжээнд ирлээ.



Банкуудын өөрийн хөрөнгөөр бий болгосон ашиг олон улстай харьцуулахад өндөр байна.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт өсөлттэй байна.



Системийн нөлөө бүхий банкууд 2024 онд олсон ашгаас 530 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараана.



Төгрөгийн хадгаламжийн өгөөж валютын хадгаламжийн өгөөжөөс өндөр байгаа нь эх үүсвэр нэмэгдэхэд нөлөөллөө.

# БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2024 он

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

Зээлийн үлдэгдэл

35%

өсөв.

# Банкны салбарын зээлийн өсөлт үргэлжилсээр.

Бодлогын хүү өндөр байгаа ч банкуудын зээл олголт өсөлттэй байна.
Эдийн засгийн идэвхжилд банкны салбарын зээл олголт чухал нөлөө үзүүлж байна.




Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

# Эдийн засгийн бүхий л салбарт зээл олголт нэмэгджээ.

Худалдаа, үйлчилгээний салбарт олгож буй зээлийн өсөлт үргэлжилж байна.
Уул уурхай, барилгын салбарын сэргэлт нь тус салбарт олгох зээл олголтыг нэмэгдэхэд нөлөөлжээ.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн эцэст




## Банкны шинээр олгосон зээл

*Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.*

Бизнесийн зээлийн хэмжээ

37%

нэмэгдэв.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

# Банкны зээлийн чанар

*Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.*

Салбарын хэмжээнд чанаргүй зээл буурчээ.

5%

## Чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 15 жилийн түүхэн доод түвшинд ирэв.

Иргэдийн хэрэглээний зээлийн чанар хэвийн түвшинд байна.
Эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байгаа нь эдийн засгийн салбаруудын зээлийн чанаргүйдлийг бууруулахад нөлөөллөө.
Уул уурхайн салбарын идэвхжил нь тус салбарын зээлийн чанаргүйдэл хоёр дахин буурахад нөлөөллөө.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн эцэст




Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн эцэст




Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

# Банкны жигнэсэн дундаж хүү

*Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.*

Хадгаламжийн хүү

11.9%

Эх сурвалж: Монголбанк

## Хүүгийн түвшин харьцангуй тогтвортой байна.

Төв банкнаас бодлогын хүүг гурван удаа бууруулсан хэдий ч зээлийн хүү харьцангуй тогтвортой байна. Хадгаламжийн хүү тогтвортой байна.



# Иргэдийн төгрөгт итгэх итгэл нэмэгдсэн нь төгрөгийн хадгаламж, харилцах нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлжээ.

Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой, инфляц аажмаар буурсан нь төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүлжээ.
Валютын харилцах 16 хувиар, валютын хадгаламж 3 хувиар тус тус буурсан байна.
.

Банкны эх үүсвэр, жил бүрийн эцэст




## Банкны эх үүсвэр

*Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.*

Банкны эх үүсвэр

15%

нэмэгджээ.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

# Банкны системийн долларжилт

*Жич: Хадгаламж болон зээлийн хэдэн хувийг валютын эх үүсвэр болон зээл бүрдүүлж байгаагаар тодорхойлогддог.*

Эх үүсвэрийн долларжилт

**23%**

байна.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

## Төгрөгийн худалдан авах чадвар сайжирсан нь эх үүсвэрийн долларжилт буурахад нөлөөллөө.

Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байсан нь төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүллээ.
Долларын эх үүсвэр аажмаар буурч байна.



# БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

**2024 он**

# Банкны актив буюу хөрөнгө

*Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд нь банкны хөрөнгө буюу актив гэнэ.*

Системийн нөлөө бүхий банкуудын актив

23%

өсөв.

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

## Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 12 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Голомт банкны актив 34 хувиар, ХХБ-ны актив 25 хувиар Хасбанкны актив 24 хувиар тус тус өсжээ.
Хаан банк болон Төрийн банкны активын өсөлт үргэлжилсээр байна.

Банкнуудын актив жил бүрийн IV улиралд



# Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх онтой харьцуулахад 5.2 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны эх үүсвэр 1.8 их наяд төгрөгөөр, ХХБ-ны эх үүсвэр 1.1 их наяд төгрөгөөр нэмэгджээ.
Голомт, Хас болон Төрийн банкны эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгджээ.

Банкнуудын эх үүсвэр жил бүрийн IV улирал




## Банкны эх үүсвэр

*Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.*

Банкуудын эх үүсвэр

**15%**

нэмэгджээ.

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

## Өөрийн хөрөнгийн өгөөж

*Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.*

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж дунджаар

**24%**

# Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс өндөр байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 6.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 17 хувиар өсжээ. Өөрийн хөрөнгөөр бий болгосон ашгийн хэмжээ өндөр байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн эцэст




Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

# Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай байна.

Банкуудын зээлийн өсөлт нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг бууруулсан хэдий ч эдийн засгийн өсөлтийг дэмжих, гол салбаруудын идэвхжилийг нэмэгдүүлэхэд хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн IV улирал




## Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

*Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг.*

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

**16.7%**

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

# Хөрвөх чадварын харьцаа

*Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.*

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж

**41%**

## Системийн нөлөө бүхий таван банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Иргэд болон бизнес эрхлэгчдэд олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байна. Зээлийн хэмжээ тасралтгүй өссөн ч банкууд хангалттай хэмжээний хөрвөх чадвартай байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа




Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

**2024 онд:** Эдийн засгийн өсөлт 4.9 хувьтай гарлаа. Уул уурхай түүнийг дагасан тээвэр, логистикийн салбарын өсөлт үргэлжилж байгаа нь эдийн засгийн сэргэлтэд чухал нөлөө үзүүллээ. Үйлчилгээ, худалдааны салбарын өсөлт харьцангуй тогтмол байгаа нь эдийн засгийн өсөлтийн ихэнх хэсгийг бүрдүүлжээ. Барилга болон боловсруулах салбар аажмаар сэргэж байна. 2024 оны эхнээс байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай байна.

**Төлөв байдал:** Манай улсын хувьд уул уурхайн бус салбар тэр дундаа барилга, боловсруулах болон ХАА-г дэмжих чиглэлээр дэд бүтцийн ажлуудыг эрчимжүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байна. Экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн ажлуудыг эрчимжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн бодлогын арга хэмжээг түргэн авахгүй бол хэт өөдрөг төсөөлсөн эдийн засгийн өсөлтөд хүрэх нь мөрөөдөл болох шинжтэй. 2025 онд уул уурхайн гаралтай түүхий эдийн экспортоос олох орлогыг өндрөөр төсөөлж төсвийн зардлыг 17  хувиар нэмэгдүүлсэн нь макро эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл дагуулж байна.

# 2024 оны байдлаар эдийн засаг 4.9 хувиар өсөв.

Уул уурхайн салбар болон түүнийг дагасан тээвэр, логистикийн салбарын өсөлт үргэлжилж байгаа нь эдийн засаг тэлэхэд чухал нөлөө үзүүллээ.
Худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт нь эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүллээ.
Боловсруулах үйлдвэр болон барилгын салбар аажмаар сэргэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.
Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбарын сэргэлт удаашралтай байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.



# Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 29.7 хувиар буурчээ.

Эрдэс бүтээгдэхүүн түүний дотор зэсийн баяжмал, төмрийн хүдрийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэн нь экспортын өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ. Нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрсэн хэдий ч дэлхийн зах зээл дээрх үнийн уналтаас шалтгаалан 2023 онтой харьцуулахад экспортын орлого буурчээ. Машин тоног төхөөрөмж, суудлын авто машин болон нефтийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдсэн нь импортын өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Зэсийн хүдэр, баяжмал, алт, төмрийн хүдрийн өсөлт нь **экспортын өсөлтөд** чухал нөлөө үзүүллээ.




Дэлхийн зах зээл дэх бараа бүтээгдэхүүний үнэ тогтворжсон нь **импортод** эергээр нөлөөлжээ.




**Гадаад худалдааны тэнцэл ашигтай** хэдий ч өмнөх оноос буурчээ.




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

# Төлбөрийн тэнцэл 622 тэрбум ам.долларын ашигтай гарч төгрөгийн ханшид ирэх дарамт бага байна.

Манай улс импортоосоо илүүтэйгээр экспортолсон нь төлбөрийн тэнцэл ашигтай гарахад чухал нөлөө үзүүллээ.
Илүү ихээр бараа, үйлчилгээ импортолж буй нь урсгал дансны алдагдалд нөлөөлсөн хэдий ч гадаадын хөрөнгө оруулалт аажмаар сэргэж, санхүүгийн данс ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүллээ.
Төгрөгийн бодит ханш чангарч манай улсын бараа, бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж байна.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш




Төлбөрийн тэнцэл




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

# Инфляцын өсөлтийн хурд аажмаар саарч нэг оронтой тоонд хүрсэн ч цаашид өсөх хандлагатай байна.

Дотоодын хүнс тэр дундаа мах болон гурилын үнийн өсөлт нь инфляц өндөр байхад чухал үүрэг гүйцэтгэж байна.
Цахилгаан, эрчим хүчний үнийг сүүлийн улиралд нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор орон сууц, ус болон цахилгааны үнийн өсөлт нь инфляц нэмэгдэхэд нөлөөлжээ.
Цалин, тэтгэврийн өсөлт нь бараа, бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлж, эрэлтийн гаралтай инфляцын түвшин нэмэгдэх суурь шалтгаан болж байна.



# Төсвийн тэнцэл 776 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

2024 оны эхнээс уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнээс олох орлого нэмэгдсэн хэдий ч орлого олох хэмжээгээр урсгал зардлыг хэт их нэмэгдүүлсэн нь төсөв алдагдалтай гарахад нөлөөллөө.
Оны II дугаар улиралд төсөвт тодотгол хийсэн нь төсвийн зарлагын өсөлтийг нэмэгдүүлэв.
Сүүлийн хоёр жил үндсэн тэнцэл ашигтай гарсан ч төсвийн урсгал зардал хэт өндөр байна.

Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 29 хувиар нэмэгджээ.

ДНБ-д эзлэх хувиар




Төсвийн зарлага өмнөх оноос 35 хувиар өсжээ.




Төсвийн алдагдал нэмэгджээ.



# Төсвийг төгөлдөржүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын төсвийг нэгтгэн нэгдсэн төсөв гаргах. Төсвийн алдагдлыг нэгтгэн тооцох

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт шалгалтыг сайжруулж урт хугацааны төлөвлөгөөтэй уялдуулах.

Мега төслүүдийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тооцож эрэмбэлэх төсөвт дарамт болохгүйгээр хугацааг нь хооронд нь уялдуулах.